

**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ**



ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН САЛБАРТ ДАЛАЙН ЗАХИРГААНААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖЛУУД

**УЛААНБААТАР ХОТ
2016 он**



2003 онд УИХ-аар батлагдан гарсан “Усан замын тээврийн тухай” Монгол Улсын хууль

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Усан замын тээврийн талаархи төрийн байгууллагын
бүрэн эрх

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл,

тусгай зөвшөөрөл

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Усан замын тээвэрлэлт

ТАВДУГААР БҮЛЭГ

Усан замын тээврийн хэрэгслийн техникийн хяналт

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Усан замын тээврийн тухай хууль тогтоомжийн

биелэлтэд хяналт тавих

ДОЛДУГААР БҮЛЭГ Бусад зүйл

7 бүлэг, 16 зүйлтэй

2005, 2011, 2015 онд нэмэлт өөрчлөлт орсон.

- “Усан замын зогсоол байгуулах, түүнийг ашиглах журам” 2005 он (Зам, Тээвэр, Аялал жуулчлалын сайдын тушаал)
- “Усан замын тээврийн хэрэгслийн техник ашиглалтын дүрэм” 2005 он (Зам, Тээвэр, Аялал жуулчлалын сайдын тушаал)
- “Усан замын тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам” 2006 он (Зам, Тээвэр, Аялал жуулчлалын сайдын тушаал)
- “Усан замын тээврийн хэрэгслээр зорчигч, ачаа тээвэрлэлтийн үйлчилгээ болон усан замын дохио, тэмдгийн угсралт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох журам 2006 он (Зам, Тээвэр, Аялал жуулчлалын сайдын тушаал)
- “Усан замын тээврийн хяналт зохицуулалт, аюулгүй ажиллагааны журам” 2007 он (Зам, Тээвэр, Аялал жуулчлалын сайдын тушаал)
- “Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам” 2014 он (Зам, Тээврийн сайд, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын хамтарсан тушаал)

ДАЛАЙН ЗАХИРГААНААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ



Усан замын тээврийн хэрэгслийн хяналтын үйл ажиллагаа, завт эргүүл

Аюулгүй үйл ажиллагааны зааварчилгаа, сургалт, семинар

Стандартын шаардлагад нийцсэн аврах хантааз хэрэглэх зөвлөмж, сурталчилгаа



Усан замын тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгох, техникийн хяналт, шалгалт



УЗТХ жолоодох эрхийн үнэмлэх олгох, сургалт зохион байгуулах

БАГА ОВРЫН УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ ЖОЛООДОХ СУРГАЛТ




Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа Далайн захиргаанаас 2004-2016 онуудад жил бүр усан замын тээврийн хэрэгслийг аюулгүй жолоодох сургалт зохион байгуулж байна.

Он	2010	2011	2012	2013	2014	2015	2016
1. Сургалтанд нийт хамрагдсан хүний тоо	50	45	20	40	32	166	150
2. Завь жолоодох эрх олгогдсон хүний тоо	38	33	12	18	18	20	29



Усан замын тээврийн хэрэгслийг жолоодож буй хувь хүмүүст өдөр тутам ашиглах сургалтын материал, гарын авлага шаардлагатай байсан тул Далайн захиргаа, бусад орны холбогдох байгууллагаас гаргасан сургалтын материалыг 2010 онд орчуулан боловсруулж, завь жолоодогч нарт зориулсан сургалтанд ашиглаж байна.



Зам, тээврийн яам, Далайн захиргаанаас 2004-2014 онуудад дараахь ажлыг тогтмол хэрэгжүүлж байна.

❑ Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, дугаар олгох үйл ажиллагаа,

❑ Усан замын тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагааны техникийн үзлэг, тооллого, хяналтыг усан замын тээврийн улсын байцаагч болон журамд заасан бусад нэгжийн хамт хэрэгжүүлэв.

❑ Нийт завь жолоодогч нарт усан замын тээврийн аюулгүй үйл ажиллагаанд хяналт тавьж, заавар зөвлөмжөөр хангах.



Дотоодын усан замын тээврийн хэрэгслийн судалгаа /График/



Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд аж ахуйн нэгж хэлбэрээр болон хувиараа үйл ажиллагаа эрхэлж буй усан замын тээврийн хэрэгсэл, зорчигчдын тоо жил тутам тогтмол өсөн нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

“Хувийн хөвөгч хэрэгсэл: 4 дүгээр хэсэг Аврах хантааз, үзүүлэлтийн түвшин -100, Аюулгүй үйл ажиллагааны шаардлагууд, MNS ISO 12402-4: 2014” стандартыг Стандартчиллын үндэсний зөвлөлийн хурлаар 2014 оны 10 дугаар сарын 03-ны өдөр хэлэлцүүлж батлуулсан.



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Хувийн хөвөгч хэрэгсэл, 4-р хэсэг:
Аврах хантааз, гүйцэтгэлийн түвшин-100
Аюулгүй ажиллагааны шаардлагууд




Албан хэвлэл

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
Улаанбаатар хот
2014 он


ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ШИНЭЧИЛСЭН БҮРТГЭЛ 2015 ОН

"Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн болон экологийн хяналтын үзлэг хийх, тоо бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам" шинэчлэгдсэнтэй холбогдуулан нийт усан замын тээврийн хэрэгслээр үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэд, эзэмшигчдэд 2015 оны 05 дугаар сараас эхлэн Далайн захиргаанаас олгох болсныг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр танилцуулсан.





Далайн захиргаа нь "Онцгой байдлын ерөнхий газар"-тай Монгол Улсын гол, мөрөн, нууранд усан замын тээврийн хэрэгслээс хүний амь нас, эрүүл мэнд эрсдэхээс урьдчилан сэргийлэх хяналтын үйл ажиллагааг сайжруулахад хамтран ажиллах, мөн төрийн байгууллагын уялдаа холбоо, хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах зорилгоор 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдөр санамж бичиг байгуулсан.



Оросын Холбооны Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайдын эдийн засгийн асуудал хариуцсан зөвлөх Дагбаин Балта Балдановичтай Далайн захиргааны ахлах мэргэжилтэн Д.Байгалмаа, мэргэжилтэн Г.Золбоо нар 10 дугаар сарын 23-ны өдөр уулзалт зохион байгуулж Монгол Улс, ОХУ-тай усан замын тээврийн үйл ажиллагааг хамтран зохион байгуулах, түүнчлэн усан замын тээврийн хэрэгслээр Сэлэнгэ, Орхон мөрнөөр тээвэр эрхлэх ажилд тусламж дэмжлэг үзүүлж хамтран ажиллах талаар хүсэлт тавьсан.





Далайн захиргаа нь "Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны захирагчийн ажлын алба"-тай Хөвсгөл нууранд усан замын тээврийн хэрэгслээс осолдох, ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учрахаас урьдчилан сэргийлэх, хяналт чиглэлээр төв болон орон нутгийн байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах, хамтын ажиллагааг шинэ түвшинд гаргах зорилгоор 2016 оны 05 дугаар сарын 11-ны өдөр санамж бичиг байгуулсан.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ХАРЬГА ДАЛАЙН ЗАХИРГАА, ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАТГАЛ ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА, ХОРОНД ХАМТРАН АЖИЛЛАХ САНАМЖ БИЧИГ

2016 оны 05 сар 11 өдөр

Дугаар...

Улаанбаатар хот

Байгаль орчныг хамгаалах тухай, Усан замын тээврийн тухай зурьт, тогтоомжийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор нэг талаас Далайн захиргаа, нөгөө талаас Хөвсгөл аймгийн Хатгал тосгоны Захирагчийн ажлын алба (ХАМТ) нь (дараах) "Талууд" гэм-ны хооронд харицран тохиоролцж энэхүү "Санамж бичиг"-ийг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДСЭЛЭЛ

3.1. Энэхүү санамж бичгийн зорилго нь Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Хөвсгөл нууранд усан замын тээврийн хэрэгслээс осолдох, ослын улмаас хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл учрахаас урьдчилан сэргийлэх, хяналт чиглэлээр төв болон орон нутгийн байгууллагуудын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулахад оршино.

3.2. Талууд, хамтын ажиллагаандаа Монгол Улсын зурьт, тогтоомжийг дахлан, байгууллага хоорондын харилцааны зохицой хэмжээг баримтлах, харицран санал болгох, зөвшилцөж, эрх тэгш байдлыг эрхэмлэн, хяналттай ажил тэд байдлыг хангах, эр бүтээлтэй хамтран ажиллах зарчмыг баримтлана.

ХОЁР. ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

2.1. Хөвсгөл нууранд усан замын тээврийн хэрэгсэл ажилтан үйл ажиллагаа явуулах буюу аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тээврийн хэрэгсэлийн аюулгүй байдал, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тавих хяналт зохицуулалтыг сайжруулахад хамтарч ажиллах.

2.2. Хөвсгөл нууранд усан замын тээврийн хэрэгсэл ажилтан үйл ажиллагаа эрхлэх буюу аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн болзолгүй агаар, ослоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөж, хэрэгжүүлэхэд нэгдсэн арга зүйн дөнгөлөг зурвиль, сургалт сурталчлалтаа зохион байгуулах.

2.3. Хөвсгөл нууранд усан замын тээврийн хэрэгсэл ажилтан үйл ажиллагаа эрхлэх буюу аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн тээврийн хэрэгсэл зөрчлөх тээвэрлэлтэд үнэн бодосгүй аргаар бууруулах талаар заавар, зөвлөмж өгөж, дэмжлэг үзүүлэх.

2.4. Хөвсгөл нуурын эрэг дунд жөл бүр тогтоол зохион байгуулдаг (ЭТЯ, ОБЕГ, Далай захиргаа) хамтарсан эвэлт эргүүлгийн хяналтад орон нутгийн захиргаа зориулан тодорхой хүнийг ашиглахын зорилгоор.

2.5. Баяр наадам аялалтын олон асартай зургаанд, Хөвсгөл нуурыг зорих иргэдийн ая тухай, далайн тийвэн аялалт, аялалт зохиолтой бүрдүүлэх үүрэгээс хэл ажилтантай чиглэлүүдэд эргүүл хяналтыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар хийж номзадүүлсэн байдлаар ажиллах.

2.6. Хөвсгөл нуурыг тусгагч усан замын тээвэр эрэлчдэд тавих хяналт зохицуулалт, аюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлүүдийг орон нутгийн Захирагчаас гаргах.

Усан замын тээврийн тухай хууль, дүрэм, журам болон бага оврын усан онгоц, завь, катерыг хэрхэн осол, аюулгүй жолоодох, аврах хантаазны стандарт, түүний ашиглалт, төрөл ангилал зэрэг аюулгүй ажиллагааны зааварчилгаа, хамтарсан сургалт зөвлөгөөнийг энэ оны 07 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд ЗТЯ, Хөвсгөл нуур Эгийн голын сав газрын захиргаа, Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын захиргаа зэрэг орон нутгийн төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Сургалт, зөвлөгөөнд нийт 166 иргэн хамрагдсан байна.




ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВЭРТ СУРГАЛТ, СЕМИНАР 2016 ОН

“Монгол Улсын усан замын тээврийн аюулгүй ажиллагаа” сэдэвт үндэсний семинар Хөвсгөл аймгийн Хатгал тосгонд 2016 оны 07 дугаар сарын 06-07-ны хооронд зохион байгуулагдсан. Үндэсний семинарт урлигаар Олон улсын далайн байгууллага (IMO)-ын төлөөлөгч, Олон улсын эрэн хайх, авран туслах холбоо (IMRF)-ны төлөөлөгч, БОНХАЖЯ, ТЕГ, ХХЕГ, ОБЕГ, МХЕГ, ИНЕГ, Архангай, Ховд, Булган аймгуудын Засаг даргын тамгын газар, МАЖХ, Хөвсгөл аймгийн аялал жуулчлалын холбоо, Хатгал тосгоны захирагчийн ажлын алба, Усан замын тээвэр эрхлэгч аж ахуй нэгж, иргэд мөн Далайн захиргааны хамт олон зэрэг нийт 150 гаруй оролцогчид оролцсон.



ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВЭРТ СУРГАЛТ, СЕМИНАР 2016 ОН

Далайн захиргааны хүсэлтээр Монголын өвлийн усанд сэлэлтийн холбоотой хамтран тус холбооны ерөнхий нарийн бичгийн дарга, спортын мастер, усанд сэлэлтийн багш Ш.Даваадорж Хөвсгөл нууранд бага оврын усан замын тээврийн хэрэгслээр тээвэр эрхлэж буй завьчдад зориулсан 14 хоногийн хугацаатай анхан шатны сургалтыг 2016 оны 07 дугаар сарын 08-22-ны хооронд зохион байгуулсан ба нийт 53 иргэн хамрагдаж 40 завьчин сертификат гардан авсан. Сургалтанд хүйтэн усанд сэлэх, аврах үйл ажиллагаа, гүний шумбалт, спортын хооллолтын тухай, эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх зэрэг хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулсан.



ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВЭРТ ХАМТРАН АЖИЛЛАХ 2016 ОН

Зам, тээврийн яам болон Монгол Улсын Далайн захиргаанаас Хил Хамгаалах Ерөнхий Газрын 0306 дугаар анги буюу ХХЕГ-ын Зэвсэг, инженер техникийн хэлтэст Усан замын хяналт болон усан хилийн хяналтад техникийн тусламж үзүүлэх үүднээс 6 хүний суудалтай, 115 морины хүчтэй Ямаха мотортой, БНХАУ-д 2016 онд үйлдвэрлэгдсэн, 638 маркын хагас, битүү катерыг ХХЕГ-ын ЗИТХ-ийн дарга хурандаа О.Батзоригт гардуулан өглөө. Уг арга хэмжээнд Зам, тээврийн сайд М.Зоригт, ЗТЯ-ны Далай ашиглалт, усан замын тээврийн хэлтсийн дарга Ж.Батболд, Далайн захиргааны дарга Х.Энхбаатар тэргүүтэй оролцсон болно. 2016.07.21



ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВЭРТ ШАГНАЛ, УРАМШУУЛАЛ 2016 ОН

Монгол Улсад усан замын тээврийн салбар бие даан хөгжсөний 64 жилийн ойг тохиолдуулан Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат салбарын “Хүндэт жуух бичиг”-ээр Хөвсгөл нууранд усан замын тээвэр эрхлэгч, завь жолоодогч иргэдийг шагнахаар шийдвэрлэсэн. Түүнчлэн Далайн захиргаанаас усан замын тээврийн салбарт тодорхой хувь нэмэр оруулж буй завьчдыг зорчигчдын амь нас, аюулгүй байдлыг хангах, байгаль орчноо хамгаалах үйлсэд идэвхи санаачлагатай ажиллаж буй иргэдийг үнэлэж Талархлын бичигээр шагнасан. 2016.08.21



ДОТООДЫН УСАН ЗАМЫН ТЭЭВЭРТ ХЯНАЛТ

Далайн захиргаа ОБЕГ хооронд хамтран ажиллах санамж бичиг байгуулан хамтран ажиллах ажлын төлөвлөгөө боловсруулж 2015 оноос эхлэн завьт эргүүлийг Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Хөвсгөл нууранд 07 дугаар сарын 01-нээс 08 дугаар сарын 25 хүртэл жил бүр зохион байгуулж байна.

Осол, зөрчил болон усанд хүний амь нас эндэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор усан замын тээврийн хэрэгслээр зорчиж буй зорчигч, жолоодогч нарт заавар, зөвлөмж өгч завьт эргүүлээр Хөвсгөл нууранд хяналт тавин ажиллаж байна.





**ЗАМ, ТЭЭВРИЙН
ХӨГЖЛИЙН ЯАМ**



ДАЛАЙН ЗАХИРГАА

Анхаарал хандуулсан таньд баярлалаа

Холбоо барих:

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Самбуугийн гудамж –11, Засгийн газрын XI байр, 603, 604, 611, 612 тоот.

Утас: 261488, 261489, 261490, 70114801

Факс: 11-310642

Цахим хуудас: www.monmarad.gov.mn

www.facebook.com/monmarad

www.twitter.com/monmarad

Цахим хаяг: info@monmarad.gov.mn